

## Understanding and using your body and mind

Family resources

# Өөрийн бие махбод болон оюун ухааны талаар ойлгож, ашиглаж сурах

Гэр бүлд зориулсан материал

Сургуулийн Өмнөх Боловсролын бодлого (Early Years Learning Framework) нь цэцэрлэг болон бага насны хүүхдэд зориулсан бүх төрлийн үйлчилгээ явуулдаг байгууллагуудын мөрдөх үндэсний хэмжээний боловсролын бодлого юм. Хүүхдийг зорилгот таван чиглэлээр сургаснаар тухайн хүүхэд сурах хатуужил, өндөр чадвартай болоход нь энэхүү бодлогын зорилго юм.

Сургалтын 3-р үр дүн бол хүүхдүүд эрүүл хүнс хэрэглэн, хөдөлгөөнтэй байж, өөрсдийгөө эерэгээр мэдрэх тухай юм. Хүүхдүүд бусадтай бат бэх харилцаа тогтоож, мөн өөрсдийн сэтгэл хөдлөлийг зөв удирдаж сурснаар эрүүл мэдрэмж, хандлагыг хөгжүүлдэг. Хүүхдүүд эрүүл хүнсийг зөв сонгож сурах ба биеийн тамирын арга хэмжээнд оролцох хөдөлгөөний үр чадварыг эзэмшснээр эрүүл, чийрэг өсөх болно.

Early Years Learning Framework-ийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл дараах линкээр орж танилцана уу:  
<https://www.acescqa.gov.au/nqf/national-law-regulations/approved-learning-frameworks>

## Утсан Орчуулгын Үйлчилгээ

Хэрвээ та дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл хүүхдийнхээ цэцэрлэг эсвэл бага насны хүүхдэд үйлчилгээ үзүүлдэг байгууллагатай холбогдоорой. Хэрвээ утсаар холбогдоход танд орчуулагчийн тусламж хэрэгтэй бол Утсан Орчуулгын Үйлчилгээний 131 450 дугаарт залган өөрийн хэл дээрх орчуулагчтай холбож өгөхийг хүсээрэй. Оператор таны хүссэн дугаар руу залган мөн тухайн шугамд орчуулагчийг таньтай холбож өгөх болно. Энэ үйлчилгээ нь үнэ төлбөргүй юм.

## Сургуульд суралцах

### Сургуулийн Өмнөх Боловсрол

### Эрүүл мэдрэмж, хандлага гэдэг нь:

Хүүхдүүд спорт, хөгжим, дүрслэх урлаг, хөдөлгөөн болон бүжгээр өөрсдийгөө илэрхийлж чаддаг байна

Хүүхдүүд өөрсдийн сэтгэл хөдлөлөө удирдаж, бусадтай хамтран ажиллаж, сэтгэл хангалуун байж чадна гэдгээ мэддэг байна

Хүүхдүүд эрүүл хүнсийг сонгосноор тэдний бие махбод эрүүл, чийрэг өсөхөд нь тусална гэдгийг мэддэг байна

Хүүхдүүд бусадтай хамт тоглон, хамт суралцаж мөн өөрсдийгөө эерэгээр мэдрэнэ

Сурагчид бусадтай холбоотой байж, эерэг харилцааг бий болгосноор эрүүл өсөж торнин, амжилт гаргах боломж бүрэн дүүрэн болно (Бүх сэдвийн хүрээнд)

Сурагчид урлагаар дамжуулан нийгэм, сэтгэл зүй болон бие махбодын эрүүл мэдрэмж, хандлагыг хөгжүүлнэ (Сэдэв: Бүтээлч урлаг)

Сурагчид өөрсдийн бие махбодод анхаарал тавьж, эрүүл хүнсний сонголт хийж сурна (Сэдэв: Биеийн тамирын боловсрол)

Сурагчид бусад анхаарал тавьж мөн бусдыг хүндлэж сурна (Сэдэв: Биеийн тамирын боловсрол)